



МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРКЫН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Мэдээлэл, технологийн үндэсний парк нь /цаашид Парк гэх/ мэдээллийн технологийн ерөнхий мэдлэг олгох, мэргэшүүлэх урт болон богино хугацааны сургалтыг хэрэглэгчдийн захиалга, байнгын хөтөлбөрт тулгуурлан зохион байгуулах, бусдаар гүйцэтгүүлэх нөхцөл, журмыг тогтоох, түүнтэй үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Энэхүү журам нь Парк болон хамтран сургалт зохион байгуулж буй гадаад, дотоодын байгууллага, их, дээд сургууль, хувь хүн (цаашид хамтрагч гэх), сургалтад хамрагдагчид (цаашид суралцагч гэх) хамаарна.
- 1.3. Парк нь гадаад, дотоодын байгууллага, их, дээд сургууль, хувь хүнтэй хамтран сургалт зохион байгуулах боломжтой бөгөөд энэ тохиолдолд хамтран ажиллах гэрээ байгуулна.
- 1.4. Сургалтыг амжилттай дүүргэсэн суралцагчдад гэрчилгээ олгоно.
- 1.5. Журмын биелэлтэд холбогдох нэгжийн удирдлага хяналт тавин ажиллана.
- 1.6. Тус журам нь Паркын болон бусад дүрэм, журмын салшгүй нэг хэсэг байна.

Хоёр. Сургалтын төрөл

- 2.1. Журмын хүрээнд дараах сургалт, арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:
 - 2.1.1. Мэргэшүүлэх сургалт (Бүх нийтийн мэдээллийн технологийн мэдлэгийг сайжруулах);
 - 2.1.2. Эрэлт хэрэгцээ, судалгаанд тулгуурласан сургалт;
 - 2.1.3. Олон улсын шалгалтуудад бэлтгэх сургалт;
 - 2.1.4. Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан сургалт;
 - 2.1.5. Хамтарсан сургалт (Гадаад, дотоодын байгууллага, их, дээд сургууль, хувь хүнтэй хамтарсан);
 - 2.1.6. Урт болон богино хугацааны захиалгат болон тусгай хөтөлбөрт сургалт (салбар болон салбар дундын байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулсан);

Гурав. Сургалтын төлөвлөгөө, хуваарь

- 3.1. Сургалтын төлөвлөгөө, хуваарийг тухайн жилийн 1 дүгээр сард багтаан гаргаж, Паркын захирлаар батлуулах бөгөөд хуваарийн дагуу сургалтуудыг зохион байгуулна.
- 3.2. Хичээлийн 1 цагийг 45 минутаар тооцож, сургалтын хөтөлбөрийг гарган, батална.

Дөрөв. Сургалтын бүртгэл

- 4.1. Суралцагч нь бүртгэлийг Паркын training.itpark.mn хаягаар болон өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.
- 4.2. Суралцагч сургалтын төлбөрийг 100% төлснөөр бүртгэл баталгаажих бөгөөд баталгаажсан тухай мэдээллийг бүртгүүлэгчдэд цахим шуудангаар мэдэгдэнэ.
- 4.3. Энэхүү гэрээний 4.2 дахь заалтыг хангасан суралцагчтай “Суралцагчийн гэрээ” байгуулснаар сургалтад хамрагдах эрх үүснэ.
- 4.4. Суралцагч нь бүртгэлээ сургалт эхлэхээс 3 хоногийн өмнө цуцалж болох бөгөөд цуцлах тохиолдолд сургалтын хураамжийн 75%-ийг буцаан олгоно.
- 4.5. Суралцагч нь сургалтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр таслах тохиолдолд сургалтын төлбөрийг буцаан олгохгүй, бусдад болон өөр суралцагчид шилжүүлэн тооцохгүй.
- 4.6. Суралцагч нь хүндэтгэн үзэх шалтгаанаар сургалтад хамрагдах боломжгүй болсон тохиолдолд холбогдох бичиг, баримтыг үндэслэн сургалтад хамрагдсан цагийг тооцон үлдэгдэл төлбөрийг буцаан олгоно.

Тав. Төлбөр тооцоо, хөнгөлөлт

- 5.1. Сургалтын төлбөрийн хэмжээг тухайн жилийн 1 дүгээр сард багтаан зах зээлийн ханштай уялдуулан тогтоож, Паркын захирлаар батлуулан нийтэд зарлана.
- 5.2. Суралцагч нь сургалтын төлбөрийг Паркын голомт банкны 1102099876 тоот дансанд төвлөрүүлнэ.
- 5.3. Суралцагчид дараах төлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ. Үүнд:
 - 6.3.1. Паркын ажилтнуудад 50%;
 - 6.3.2. Паркын ажилтнуудын хүүхдүүдэд 50%;
 - 6.3.3. Инкубаторын компанийн ажилтнуудад 40%;
 - 6.3.4. Их, дээд сургуулийн оюутнуудад 30%;
 - 6.3.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 60%;
 - 6.3.6. Салбар болон салбар дундын хамтын ажиллагаатай байгууллага, паркаас зохион байгуулсан сургалт, шалгалт, арга хэмжээнд оролцон шагналт байр эзэлсэн оролцогчдод Паркын захирлын шийдвэрийг үндэслэн 100% хүртэлх хөнгөлөлт үзүүлж болно.
- 5.4. Энэхүү журмын 2.1.5, 2.1.6-д заасан сургалтыг зохион байгуулах тохиолдолд сургалтын орлогыг 30:70 эсвэл 40:60 хувийн харьцаагаар хуваарилна. Энэ тохиолдолд нийт орлогын 30% эсвэл 40% (өрөө танхим болон тоног, төхөөрөмж ашиглалтын зардал)-ийг Парк, 70% эсвэл 60%-ийг хамтрагч талд олгоно.

Зургаа. Хариуцлага

- 6.1. Суралцагч болон хамтрагч нь энэхүү журмыг зөрчвөл холбогдох хууль, дүрэм, журам болон гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээнэ.
- 6.2. Суралцагч болон хамтрагч нь Паркаас өгсөн гарын авлага, бусад холбогдох материалыг цахим болон цаасан хэлбэрээр бусдад шилжүүлэх, хувилах, олшруулах, цахим сүлжээнд нийтлэхийг хориглоно. Зөвшөөрөлгүй тараасан, нийтэлсэн тохиолдолд хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- 6.3. Суралцагч болон хамтрагчийн хайхрамжгүй байдлаас шалтгаалан компьютер, тоног, төхөөрөмж, эд хогшил эвдэрч гэмтсэн тохиолдолд энэхүү гэрээний Хавсралт 1-д

заасан “Тоног, төхөөрөмж хүлээлцэх акт”-ын үнийн дүнг баримтлан байгууллагыг хохиролгүй болгоно.

Долоо. Бусад

- 7.1. Сургалттай холбоотой санал, хүсэлт, гомдлыг МТҮП-ын info@itpark.mn цахим шуудангаар ирүүлж болно.